



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/4

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дах хэсэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2022 оны ХЭГ/19 дүгээр албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар компанийн Говийн бүсийн салбарын Сургалт, бүтээмжийн инженер Ц.Батсүхээс ирүүлсэн гомдолд дурдсан асуудлын хүрээнд хяналт, шалгалт хийж, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч Ц.Шинэхүү	Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын албаны дарга
---------------------	--

Нарийн бичгийн дарга Б.Билгүтэ	Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
-----------------------------------	---

Гишүүд:

Ө.Саранцэцэг	Хууль, эрх зүйн хэлтсийн хуулийн мэргэжилтэн
--------------	--

Г.Нямдаваа	Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
------------	---

Я.Мөнхтөр	“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Хяналт, мониторингийн хэлтсийн дарга
-----------	---

2. Ажлын хэсгийн баримталж ажиллах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Удирдамжид заасан асуудлыг хянан үзэж дүгнэлтээ 2022 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн дотор тайлагнахыг Ажлын хэсэг (Ц.Шинэхүү)-т даалгасугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

132003138

ТӨБЗГ тушаал-/2021

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын  
-ны өдрийн 4/4 дугаар тушаалын хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

НЭГ. Ажлын зорилго

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Говийн бүсийн салбарын зохион байгуулалтын бүтэц, боловсон хүчний асуудал, удирдлагын үйл ажиллагаа, Компанийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх асуудлыг судалж, газар дээр нь очиж холбогдох тайлбарыг гаргуулан авч нэгтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргад танилцуулан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх.

ХОЁР. Ажлын хүрээнд хамрагдах байгууллага

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК

ГУРАВ. Ажиллах хугацаа

Ажлын хэсэг 2022 оны 01 дүгээр сарын 24-28-ны өдрүүдэд ажиллана.

ДӨРӨВ. Ажлын хамрах хүрээ

4.1. Боловсон хүчний асуудлын талаарх дүрэм, журам түүний хэрэгжилттэй холбогдох баримт, компанийн бүтэц зэрэг материалтай танилцаж дүгнэлт гаргах.

4.2. Компанийн ажилтнуудын ажил үүргийн хуваарьт үнэлэлт, дүгнэлт өгөх.

ТАВ. Дүгнэлт

5.1. Ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу ажиллаж, дүгнэлт гаргана.

5.2. Дүгнэлтийг 2021 оны 01 дүгээр сарын 28-ний өдөр газрын удирдлагад танилцуулан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.